



ХАТУУ ХӨЛ ХОРИОНЫ ҮЕИЙН ХУВИАРАА БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

2020.11.26

Агуулга

Дүгнэлт	2
1. Үйл ажиллагаанд үзүүлж буй нөлөө.....	3
1.1 Ажлын байранд үзүүлж буй нөлөө	4
1.2 Санхүүгийн байдалд үзүүлж буй нөлөө	5
2. Тулгарч буй хүндрэл ба шаардлагатай дэмжлэгүүд.....	7
2.1 Тулгарч буй хүндрэл.....	7
2.2 Шаардлагатай дэмжлэгүүд	7

Дүгнэлт

МҮХАҮТ-аас 2020 оны 11 дүгээр сарын 23-25-ны өдрүүдэд хатуу хөл хорионы үед бизнесийн нөхцөл байдлыг үнэлэх зорилгоор Улаанбаатар хот, орон нутгийн бизнес эрхлэгчдийн дунд цахим хэлбэрээр 2020 оны 11 сарын 23-25-ны өдрүүдэд судалгааг явуулаж 3530 аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдийг хамруулсан. Судалгаанд оролцогсдын 13 хувь буюу 445 нь хувиараа бизнес эрхлэгчид байсан бөгөөд тэдгээрт тулгарч байгаа зарим асуудал, шаардлагатай дэмжлэг талаар нийт судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдээс ялгаатай байсан тул “Хатуу хөл хорионы үеийн хувиараа бизнес эрхлэгчдийн нөхцөл байдал” хавсралт тайланг гарган танилцуулж байна.

Хатуу хөл хорио тогтоосон энэ хугацаанд нийт судалгаанд оролцогсдын 66 хувь нь бүрэн зогссон бол хувиараа бизнес эрхлэгчдийн 82 хувь нь бүрэн зогсолт хийж үйл ажиллагаа явуулаагүй гэсэн хариултыг өгсөн байна. Хувиараа бизнес эрхлэгчдийн ирүүлсэн судалгааны үр дүнд ажлын байраа хадгалах боломж нь нэг сар хүртэлх хугацаанд дийлэнх нь буюу 64 хувь нь ажлын байраа хадгалж чадна, мөн нэг сар хүрэхгүй гэсэн үр дүн гарч байна.

Хатуу хөл хорионы дэглэм тогтоосонтой холбоотойгоор аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдэд үүсээд буй хүндрэл, бэрхшээлийн хувьд 67 хувь нь зээлийн эргэн төлөлт, 61 хувь нь түрээсийн төлбөр, 55 хувь нь ажлын байраа хадгалах, ажиллагсадын цалин тавих нь хамгийн хүндрэлтэй байна гэж хариулжээ.

Харин хатуу хөл хорионы үед аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдэд Засгийн газраас ямар төрлийн дэмжлэг шаардлагатай байгааг тодруулахад давхардсан тоогоор судалгаанд оролцогсдын 58 хувь нь бизнесийн үйл ажиллагааг тодорхой хувиар үргэлжлүүлэх боломж олгох, 41 хувь нь зээлийн төлбөр, хүү төлөх хугацааг хойшлуулах, 39 хувь нь зээлийн хүүг бууруулах шаардлагатай байна гэсэн байна.


Хөл хорио дууссаны бизнесийг үйл ажиллагаагаа сэргэхэд санхүүгийн дэмжлэг хамгийн хэрэгтэй гэж судалгаанд оролцогсдын 57 хувь, хөнгөлөлттэй зээл авах 49 хувь, зээлийн хүү бууруулах гэж 44 хувь нь хариулжээ.

Хувиараа бизнес эрхлэгч нар нь хөл хориотой үед бүрэн зогсолт хийсний улмаас борлуулалтын орлого нь эрс буурах буюу ямар нэг орлогогүй болсноос тогтмол зардал төлж чадахааргүй болсон нь тодорхой харагдаж байна. Аажмаар энэхүү хөл хорио нь одоогийн байдлаар үргэлжилсэн тохиолдолд тухайн бизнес эрхлэгч нар нь төлбөрийн асуудалд орж хориг тавигдсаны дараа ойрийн хугацаанд бизнесээ эргэж сэргээх нь асуудалтай болохоор байна. Тэдний хүсэж байгаа зүйл нь зээл болон тогтмол зардлын төлөлтийн хугацаа хойшлуулж тодорхой хэмжээгээр үйл ажиллагаа эрхэлж аажмаар тухайн зардлыг төлөх саналтай байна. Улсаас зарим салбарын үйл ажиллагаа сэргээж, зайнаас буюу цахимаар ажиллах боломжгүй салбарыг халдвар хамгаалалтын нарийн журам гаргаж ажиллуулах нь зүйтэй гэж хариулсан байна.

1. Үйл ажиллагаанд үзүүлж буй нөлөө


Үйл ажиллагаа явуулж буй эсэх дээр хувиараа бизнес эрхлэгчдийн 82 хувь нь бүрэн зогсолт хийж үйл ажиллагаа явуулаагүй, 13 хувь нь хязгаарлагдмал хүрээнд ажиллаж байгаа гэсэн байна. (Зураг 1.1)

Зураг 1.1. Хөл хорионы үед аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаа явуулж буй байдал



Хөл хорионы үеэр үйл ажиллагаагаа явуулах хэрхэн явуулах тухай тодруулахад 35 хувь нь компанийн зүгээс халдвар хамгааллын дэглэмийн хүрээнд тодорхой дүрэм, журам гаргаж нарийн мөрдөж ажиллах боломжтой гэсэн бол 24 хувь нь халдвар хамгааллын дэглэмийн хүрээнд ажиллагсдын тодорхой хувийг ажиллуулах боломжтой гэсэн хариулт өгсөн. (Зураг 1.2)


Зураг 1.2. Хөл хорионы үед үйл ажиллагаагаа зохион байгуулах боломжтой хувилбарууд



1.1 Ажлын байранд үзүүлж буй нөлөө


Хатуу хөл хорионд өөрийн нөөцөөр ямар хугацаанд ажлын байрны тоог өөрчлөхгүй хадгалж үлдэх боломжтой тухай тодруулахад 64 хувь нь нэг сар хүртэл гэсэн бол 26 хувь нь 1-3 сарын хугацаанд ажлын байр хадгалах боломжтой гэсэн. Өөрөөр хэлбэл судалгаанд оролцсон хувиараа бизнес эрхлэгчдийн 90 хувь нь 3 сараас дээш хугацаанд ажлын байраа хадгалах боломжгүй гэжээ. (Зураг 1.3)

Зураг 1.3. Хувиараа бизнес эрхлэгчдийн ажлын байраа хадгалах боломжтой хугацаа




Бизнес эрхлэгчдээс ажлын байрыг цөөрүүлсэн эсэх талаар асуухад 26 хувь нь цомхотгосон гэсэн бол ирээдүйд хөл хориотой тохиолдолд хийх талаарх асуултанд 52 хувь нь хийнэ гэсэн хариулт өгсөн. Цомхотгол хийнэ гэсэн хувиараа бизнес эрхлэгчид одоогийн байдлаар 20 орчим хувь нь 5 хүртэл ажилчдаа цомхотгосон, он дуустал хөл хорио үргэлжлүүлбэл 50 хувь нь нэмж цомхотгоно гэсэн бол 3 сар хөл хориотой тохиолдолд 43 хувь нь бизнесийн үйл ажиллагаа зогсооно гэсэн байна. (Зураг 1.4)

Зураг 1.4. Хөл хорионы дэглэмийн ажлын байрны тоонд үзүүлж буй нөлөө



Үүнээс гадна ихэнх нь өөрийн хөрөнгийн нөөц нь нэг сар хүртэл хүрэлцэхгүй гэж гарсан (зураг 1.3) днь бизнес эрхлэгчид нь борлуулалтын орлогоороо өдөр тутмын ажлын зардлыг бүрэн дааж явдаг ба хуримтлал муу байдгийг харуулж байгаа юм. Ийм ч учраас ажилчдын цалин тавихад хүндрэлтэй байна. (Зураг 1.5)


Зураг 1.5. Хатуу хөл хорионы дэглэмийн ажиллагсдын цалинд үзүүлж буй нөлөө



1.2 Санхүүгийн байдалд үзүүлж буй нөлөө


Хувиараа бизнес эрхлэгчдээс өөрсдийн хуримтлал болон хөрөнгөөр бизнесийн хэвийн үйл ажиллагааг авч үлдэх боломжийн талаар асуухад 78 хувь нь 1 сар хүртэлх хугацаанд, 18 хувь нь 1-3 сарын хугацаанд бэлэн мөнгөний нөөц нь хүрэлцээтэй гэж хариулсан. Өөрөөр хэлбэл судалгаанд оролцогсдын 96 хувь нь 3 сар хүртэл өөрийн хөрөнгө нь хүрэлцээтэй гэж хариулсан байна. (Зураг 1.6)

Зураг 1.6. Аж ахуйн нэгжүүдийн бэлэн мөнгөний хүрэлцээтэй хугацаа




Нийт судалгаанд оролцогчдийн 72 хувь нь борлуулалтын орлого 90 хувиас дээш хэмжээгээр буурсан гэсэн үзүүлэлт байгаа бол хөл хорио цаашид үргэлжлэх тохиолдолд энэ үзүүлэлт нь он дуустал 78 хувь, 3 сарын хугацаанд 79 хувьд хүрэхээр байна. (Зураг 1.7)

Зураг 1.7. Борлуулалтын орлогонд үзүүлж буй нөлөө



Үүнээс гадна хувиараа бизнес эрхлэгчдийн 67 хувь нь ямар нэгэн зээлтэй бөгөөд түүнээс 46 хувь нь 50 нь сая хүртэл төгрөгний зээлтэй, 14 хувь нь 50-100 сая хүртэл төгрөгний зээлтэй байна. (Зураг 1.8)

Зураг 1.8. Хувиараа бизнес эрхлэгчдийн зээлийн хэмжээ




Олон нийттэй харьцдаг хоолны газар, дэлгүүр, үсчин гэх мэт үйлчилгээний салбаруудын орлого нь зогсож бүрэн зогсолт хийсэн гэж нэмэлт мэдээлэл явуулсан байна.

2. Тулгарч буй хүндрэл ба шаардлагатай дэмжлэгүүд

2.1 Тулгарч буй хүндрэл

Бизнес эрхлэгчдийн дунд тулгарч буй хүндрэлтэй асуудлын талаар асуухад давхардсан тоогоор нийт хувиараа бизнес эрхлэгчдийн 67 хувь нь зээлийн эргэн төлөлт хийхэд хэцүү байна гэсэн бол 61 хувь нь түрээсийн төлбөр төлөх боломжгүй, 55 хувь нь зөвшөөрөгдсөн үйл ажиллагааны зөвшөөрөл авах үйл ажиллагаа, 46 хувь нь улс төрийн шийдвэр ойлгомжгүй ба уялдаа холбоогүй болон 15 хувь нь түүхий эдийн олдоц муу байна гэсэн хариулт өгсөн. (Зураг 2.0)

Зураг 2.0. Хувиараа бизнес эрхлэгчдэд тулгарч буй асуудлууд.



Ихэнх хувиараа бизнес эрхлэгч нь орлогогүй болсоноос мөнгө санхүүгийн асуудалд орсон нь дээрх графикт(Зураг 2.0) харагдаж байгаа бөгөөд тэдний гол тулгарч байгаа асуудлууд нь хугацаат мөнгөн төлбөр төлөх боломжгүй болсон нь харагдаж байна.

2.2 Шаардлагатай дэмжлэгүүд

Хөл хорионы үед

Хувиараа бизнес эрхлэгч нар хөл хориотой үе дуустал төрөөс хамгийн их хүсэж байгаа зүйл бол бизнесийн үйл ажиллагааг тодорхой хувиар үргэлжлүүлэх боломж олгох (58 хувь) гэсэн бол зээлийн төлбөр, хүү төлөх хугацааг хойшлуулах (41 хувь), Зээлийн хүүг бууруулах буюу хөнгөлөлт үзүүлэх (39 хувь), Хатуу дэглэмийг зарим салбаруудад сулруулах (38 хувь), Түрээсийн зардлыг хөнгөлөх болон санхүүжүүлэх (32 хувь), Цахилгаан, дулаан, усны төлбөрийг төрөөс хөнгөлөх болон санхүүжүүлэх (29 хувь), Төрийн шийдвэр, тогтоомжийг тодорхой гаргах, уялдаа холбоог сайжруулах (27 хувь), НДШ-ийн төлбөрийг хөнгөлөх, төлөх хугацааг хойшлуулах (22 хувь) гэж хариулсан. (Зураг 2.1)

Зураг 2.1. Хөл хорионы үед хувиараа бизнес эрхлэгчдэд шаардлагатай дэмжлэгүүд



Хариултуудаас харахад бизнесийн үйл ажиллагаагаа бүрэн биш ч гэсэн тодорхой хувиар явуулах нь чухал гэж үзэж байна.

Хөл хорио дуусаны дараа

Хөл хорио дууссаны дараа хувиараа бизнес эрхлэгчид санхүүгийн дэмжлэг (57 хувь) бол хөнгөлттэй зээл олгох (49 хувь), Зээлийн хүүг бууруулах (44 хувь), татварын хөнгөлөлт, чөлөөлөлт (38 хувь), Зээлийн төлбөр, хүү төлөх хугацааг хойшлуулах (33 хувь), НДШ-ийн төлбөрийг хөнгөлөх, төлөх хугацааг хойшлуулах (25 хувь), Экспорт, импортын бараа бүтээгдэхүүнийг гаалийн хөнгөлттэй нөхцлөөр нэвтрэх боломж бүрдүүлэх (24 хувь) гэсэн хариултуудыг өгсөн. (Хүснэгт 1.0)

Хүснэгт 1.0 Хөл хорио дууссаны дараа шаардлагатай дэмжлэг

Санхүүгийн дэмжлэг	57%
Хөнгөлөлттэй зээл олгох	49%
Зээлийн хүүг бууруулах (хүүгийн хөнгөлөлт үзүүлэх)	44%
Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт	38%
Зээлийн төлбөр, хүү төлөх хугацааг хойшлуулах	33%
НДШ-ийн төлбөрийг хөнгөлөх, төлөх хугацааг хойшлуулах	25%
Экспорт, импортын бараа бүтээгдэхүүнийг гаалийн хөнгөлттэй нөхцлөөр нэвтрэх боломж бүрдүүлэх	24%